

СЭТГҮҮЛ ЗҮЙН СУДЛАЛД ШИНЭЛЭГ АЛХАМ ХИЙСЭН БҮТЭЭЛ

М.Зулькафиль*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.Dr.)

Түлхүүр үгс: нийгмийн оюун санаа, соён гэгээрэл, нийгмийн ёс суртахуун, нийгмийн ёс зүй, бүтээлч сэтгэлгээ, оюуны чадамж, ёс зүйн мэдрэмж, соён гэгээрүүлэх үүрэг

Сүүлийн жилүүдэд сэтгүүл зүйн судлалын сэдвийн хүрээ тэлж, тодохой нэг асуудлыг сонгон авч гүнзгийрүүлэн судлах, нийгэм-хүмүүнлэгийн бусад шинжлэх ухааны зааг дээр авч үзэх хандлага ажиглагдаж байгаа нь сэтгүүл зүй судал дахь шинэлэг алхам мөн юм. Тийм бүтээлийн нэг бол өнгөрсөн жил “Монголын шилдэг нийтлэл” цувалын 49 дэх боть болон хэвлэгдсэн Сэтгүүл зүйн шинэхэн доктор Дэмбэрэлийн Нарантуяагийн “Монголын нийгмийн оюун санааны амьдралд МҮОНТ-ийн үүрэг, оролцоо” хэмээх бүтээл юм. Үндсэн гурван бүлгээс бүрдсэн энэхүү бүтээлийн “Теле-нийтлэл, тэмдэглэл, эсээ” хэмээх нэгдүгээр бүлэгт зохиогчийн МҮОНТ-д сэтгүүлч, редактораар ажиллах үед сэтгүүл зүйн янз бүрийн бичлэгийн төрөл, зүйлээр бичсэн 21 нийтлэлийг оруулсан бол номын “Судалгааны өгүүлэл” хэмээх гуравдугаар бүлэгт нийгмийн оюун санаа

ба сэтгүүл зүйн хоорондох харилцан хамаарлын асуудлыг янз бүрийн өнцгөөс хандсөн арваад судалгааны өгүүлэл багтжээ. Харин миний анхаарлаа хандуулж, нэлээд дэлгэрэнгүй авч үзээд санал бодлоо хэлэх бүлэг бол “Монголын нийгмийн оюун санааны амьдралд МҮОНТ-ийн үүрэг, оролцоо” хэмээх хоёрдугаар бүлэг юм.

Энэхүү хоёрдугаар бүлэгт багтсан судалгааны нэг сэдэвт бүтээлийн “Нийгмийн оюун санааны амьдралын тухай ойлголт ба телевизийн хамаарал” хэмээх нэгдүгээр бүлэгт судлаач “нийгмийн оюун санаа” гэгч ойлголтын үүсэл, хувьсал хөгжил, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхой жишээ баримтын үндсэн дээр тодруулж, үүний үр дүнд “нийгмийн оюун санааны амьдрал” хэмээх ойлголтыг нэлээд өргөн хүрээнд авч үзжээ. Ингэхдээ судлаач Грекийн их сэтгэгчид Платон, Аристотель, Пифагор, Германы их сэтгэгч Гегель, Шопенхауэр, Ницше, Италийн математикч Кампанелла, Голландын философич Спиноза, Францын философич Анри Бергсон, Америкийн философич Жон Дью, Английн

философич Бертран Рассель нарын бүтээлд тулгуурлан “нийгмийн оюун санаа” хэмээх ойлголтод арай өөр өнцгөөс хандаж өөрийн гэсэн дүгнэлт хийхийг оролдсон нь сонирхолтой бөгөөд сэтгүүл зүйг бусад шинжлэх ухаантай холбон судлахыг сонирхогчдод чухал эх сурвалж болохоор байна. Судлаач дээр нэр дурдагдсан болон бусад олон арван сэтгэгч, философич, сэтгэл судлаач нарын өгсөн янз бүрийн тодорхойлолт, үнэлэлт дүгнэлтийг үндэслэн “нийгмийн оюун санаа” хэмээх ойлголт нь дотроо нийгмийн ёс суртахуун, нийгмийн ёс зүй, нийгмийн ухамсар, нийгмийн сэтгэлгээ, нийгмийн үзэл санаа хандлага, нийтийн зорилго алсын хараа, нийгмийн үнэт зүйл, нийгмийн эв нэгдэл итгэл үнэмшил, нийгмийн соён гэгээрэл зэрэг хүн төрөлхтний оршихуйн тулах цэг болсон хэдэн янзын төрөл хэлбэр, өгөгдөл үзэгдлүүдийг багтаасан цогц зүйл юм байна” (Д.Нарантуяа, 2023) гэж үзээд “...амьдарч буй нийгмээ мэдэж, ухамсарлан ойлгож, оршин байхын учир утгыг ухаж, зорилго чиглэл нь юу вэ гэдгийг бодож тунгаах, хаашаа чиглэж, ямар болоход нь өөрийн хувь нэмрээ оруулдаг хариуцлагатай, мэдлэг боловсролтой, оюуны чадамжтай, ёс зүйн мэдрэмжтэй, ёс суртахууны хэм хэмжээгээ мэддэг иргэдтэй байх эсэх нь нийгмийн оюун санааны амьдралын хөгжил төлөвшлийн гол хэмжүүр болно” (Д.Нарантуяа, 2023) гэж дүгнэсэнтэй санал нэг байна. Мөн зохиогч нийгмийн оюун санаанд нөлөөлөх түүх, соёл, хүн, хууль, мэдлэг, мэдээлэл, цаг хугацааны хүчин зүйлс, гадаад хүчин зүйлс зэрэг хүчин зүйсийг тусгайлан авч

үзээд сэтгүүл зүй ч нийгмийн оюун санааны амьдралын судалгааны салшгүй хэсэг бөгөөд тэр тусмаа хүн төрөлхтний оюун санааны амьдралд цоо шинэ үзэгдэл болсон телевизийн хөгжлийн нөлөөлөл, үүрэг оролцоог тухайлан авч судлах бүрэн боломжтой судалгааны талбар мөн гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, зохиогч телевизийг яагаад нийгмийн оюун санаатай холбон судлах болсон шалтгааныг ул суурьтай, итгэл үнэмшилтэй гаргаж өгчээ. Тиймээс судлаач Монголын нийгмийн оюун санааны амьдралд телевизийн эзлэх байр суурь ямар байгааг МҮОНТ-ийн жишээн дээр олон арван баримт, Монголын нэрт судлаачдын хийсэн дүгнэлт, үзэл баримтлалд тулгуурлан тодорхойлж, өөрийн гэсэн үнэлэлт дүгнэлт хийсэн нь анхаарал татахуйц болжээ.

Мөн энэ бүлэгт МҮОНТ-ийн соён гэгээрүүлэх үүрэг ба нийгмийн оюун санааны амьдралын харилцан хамаарлын тухай асуудлыг нэлээд дэлгэрэнгүй авч үзээд “Мэдэхгүйгээ мэдэх, мэдэхгүй зүйлсээ мэдэж авахын тулд суралцах, сурч мэдсэнээ ухаарч танин мэдэх, танин мэдсэнээ сайн сайхны төлөө зориулах хүмүүжил төлөвшлийг олох, хүний нийгэмд хүмүүнлэг амьдрах, ёс суртахуунтай, ёс зүтэй, ухамсартай, зөв сэтгэлтэй, өөдрөг үзэлтэй, бүтээлч сэтгэлгээтэй, эерэг хандлагатай байж бусдыг үлгэрлэн дагуулах мэдлэг туршлагыг хуримтлуулж, оюун санааны хувьд төгөлдөрших, өөрийн ухаантай байж түүнийгээ дагах зоригтой байх явдал нь соён гэгээрэл мөн” (Д.Нарантуяа, 2023) гэсэн дүгнэлт хийж, үүнийг МҮОНТ-ийн үйл

ажиллагаатай холбон тайлбарлахыг оролдсон нь шинэлэг болжээ. Дээрх тодорхойлолтыг үндэслэн телевизийн соён гэгээрүүлэх үүрэг бүхий нэвтрүүлгүүдийн гол чиглэлүүд, үндсэн шинжүүдийг тодруулж, ийм нэвтрүүлгүүд нь тодорхой хэмжээнд онол мэдлэг, сургаал номлол, сургамж зөвлөмжийн агуулгатай байдаг ч түүнийхээ тунг тааруулах нь хувь хүн уран бүтээлчийн мэргэжлийн ур дүйтэй холбоотой гэж үзсэн байна. Харамсалтай нь өнөөдөр манай ихэнх телевизийн уран бүтээлчдэд энэ чадвар туйлын хангалтгүй байгааг хэлэх хэрэгтэй. Бүтээлийн “МҮОНТ нийгмийн оюун санааны амьдралд нөлөөлөх нь” хэмээх хоёрдугаар бүлэгт бүх нийтийн байх, олон төрөл агуулгатай байх, хараат бус байх, бодлого үйл ажиллагааны хувьд ялгагдахаар байх зэрэг олон улсын ОНТ-ийн суурь зарчмуудын талаар дэлгэрэнгүй ойлголт өгч, МҮОНТ-ийн бодлого, үйл ажиллагаа нь дээрх зарчмуудад хэр зэрэг нийцэж байгааг тодорхой жишээ баримтуудын үндсэн дээр гаргахыг хичээсэн нь арга зүйн хувьд зөв бөгөөд шинэлэг хандлага юм.

Ингэхдээ судлаач МҮОНТ-ийн нэвтрүүлгүүдийн зорилго чиглэл, агуулга хэлбэр, үр өгөөжид хийсэн контент-анализ, бүтэц-үүргийн судалгаа, ажиглалтын арга болон үзэгчдийн дунд явуулсан түүвэр судалгааны дүнг үндэслэн МҮОНТ нь байгууллагынхаа эрхэм зорилгод хүрч чадаж байгаа эсэх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, түүний хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа зэрэг асуултад тодорхой хэмжээгээр хариулт өгч чадсан байна. Дээрх зарчмуудыг нэгбүрч-

лэн авч үзээд эерэг ба сул талын аль алиныг үнэслэлтэй, ул суурьтай гаргаж өгсөн нь оновчтой болжээ. Тухайлбал, “...Онцгой тохиолдолд дугарах ёстой телевизийн станцын суурин дээр амралтын газар байгуулсан. ...олон ястны хэл соёлыг хадгалан хамгаалах зорилготой байгуулагдаж, буриад, тува, казах хэл дээр мэдээллийн хөтөлбөр явуулж эхлээд байсан алба нэгжээ татан буулгасан нь ...соёлын янз бүрийн байдлыг хөхиүлэн дэмжих, олон ястны хэл соёлыг хүндэтгэх дэвшилтэт хандлагаасаа ухрсан үйл явдал болсон. ...Тэгэхлээр МҮОНТ-д бүх нийтийн байх зарчим бүрэн дүүрэн хангагджээ гэж дүгнэх боломжгүй байна” (Д.Нарантуяа, 2023) гэж дүгнэсэнтэй санал нэг байна. Мөн тооны араас хөөцөлдөж хэт олон төрөл жанрын бүх сэдвийг хөндсөн нэвтрүүлэг бэлтгэх хандлагатай байгаагаас зарим нэвтрүүлгийн чанар тааруу, тогтмол бус, хэт нуршуу байгаад шүүмжлэлтэй хандаж, олон нэвтрүүлэг хийхээс илүү чанартай цөөн хөтөлбөрийг сайн хийх асуудалд анхаарч чадвал нөөцөө зөв ашиглах боломж байгааг сануулжээ. Улаанбаатар хотын 6 дүүрэг, 5 аймгийн үзэгчид болон Япон, БНСУ, АНУ-д ажиллаж амьдарч буй монголчуудын төлөөлөл болсон 1509 хүнээс авсан санал асуулгын дүнд тулгуурлан “...цаашид МҮОНТ нэр төрөө сэргээх, үнэ цэнээ нэмэгдүүлэх, үзэгчдээ алдахгүй байх, ирээдүйн үзэгчдээ бэлдэх, шинжлэх ухаан танин мэдэхүйн нэвтрүүлгүүддээ ач холбогдол өгөх, судалгаа тандалт хийх институцийн үйл ажиллагааг үндсэн бүтэцдээ суулгах, ОНРТ-ийн тухай хуулийг олон нийтэд

таниулан сурталчилж, олон нийттэй нягт хамтран ажиллах замаар “хөгжлийн ирээдүй хийгээд оршихуйн үзэл баримтлалаа шинээр боловсруулах” зайлшгүй шаардлага бий болжээ. Үүний тулд хууль эрх зүйн тулгамдсан асуудлууд, дотоод гааад нөлөөллийн хүчин зүйлсээ таних, үзэл баримтлалаа шинэчлэх, ололт дутагдлаа хүлээн зөвшөөрөч, засаж залруулаад цааш явах хэрэгтэй байна болж байна (Д.Нарантуяа, 2023) гэж гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй юм. Учир нь бусад сэтгүүл зүй судлаачдын телевизийн талаар хийж байсан зарим судалгааны дүн болон МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимээс явуулж байсан санал асуулгын дүн ч Д.Нарантуяа судлаачийн дүгнэлттэй ойролцоо байгаа нь судлаач бидэнд итгэл үнэмшил төрүүлж байна.

Мөн МҮОНРТ-ийн хамгийн сул тал, эмзэг хэсэг нь улс төрөөс хараат байдал гэдгийг судалгаагаар нотлоод бүх төрлийн томилгоо нь улс төрөөс хамааралтай болж, улс төрчид, төр засгийн эрх мэдэлтнүүд өөрсдийн студи, сайт, хэвлэлийн төлөөлөгчөөр мэдээ материал бэлдүүлж ОНТ-ээр цацуулж, төрийн бараг бүх нөлөө бүхий байгууллагууд тусгай цагуудтай болж, долоо хоног бүр тусай хөтөлбөр гаргуулж байгаа нь МҮОНРТ-ийн редакцын хараат бус байдлыг ноцтой зөрчиж байна гэж дүгнэжээ. Судлаачийн ийм маягаар “...хамгийн гол суурь зарчим болох хараат бус байх зарчим алдагдсанаар тус байгууллагын нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх, нэр төрийн уналтад орж, юу ч хийсэн үнэлэгдэхгүй болж, цаашлаад оршин тогтнолын асуудал хөндөгдөхөд хүрч

мэдэхээр байна” (Д.Нарантуяа, 2023) гэж үзсэн нь гашуун боловч үнэн юм. Үүнийг засаж залруулах гол арга нь ОНРТ-ийн тухай хуульд өөрчлөлт оруулах явдал мөн. Гэхдээ хуульд өөрчлөлт оруулах, алдаа дутагдлыг засаж залруулах талаар ОНРТ-ийн Удирдах зөвлөл болон удирдах ажилтнууд идэвх санаачилга гаргахгүй байгаа нь, зарим нь хуулийн заалтыг засаж залруулах сонирхолгүй байгаагаас ОНРТ-ийн үйл ажиллагаа сайжрахгүй, олон нийтийн оюуны хэрэгцээ шаардлагаас хөцөрч, коммунист нийгмийн сэтгэлгээний тойргоос гарч чадахгүй амиа аргацаасан байдалд орсон нь үнэн юм. Судлаач энэ талаар нэлээд дэлгэрэнгүй өгүүлж, хуулийн зөрчилтэй заалтуудыг нэгбүрчлэн авч үзээд засаж залруулах боломж, арга замын талаар зөвлөмжийн шинжтэй цөөнгүй зүйлийг санал болгосон нь энэ бүтээлийн хамгийн үнэ цэнтэй, практик ач холбогдолтой хэсэг байж болох юм. Тиймээс энэ бүтээлийн талаар доктор, профессор Л.Норовсүрэн “МҮОНТ нийгмийн оюун санааны амьдралд хэрхэн нөлөөлж, эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж, дархлааг буй болоход ямар үүрэг гүйцэтгэх ёстой хийгээд, энэ чиглэлд гарч байгаа ахиц дэвшил, дутагдал доголдлыг судалгаанд тулгуурлан олон талаас нь шинжилж үзсэнд энэ ажлын бас нэг үнэт чанар оршиж байна” (Д.Нарантуяа, 2023) гэж онцлон тэмдэглэсэнтэй санал нэг байна.

Бүтээлийн энэ бүлэг дэх анхаарал татахуйц хэсэг бол МОНТ-ийн нийгмийн оюун санааны амьдралын олон талт шинэ эрэлт хэрэгцээг хангах чадамжийн талаарх

асуудлыг тусгасан 2.3 дахь хэсэг юм. Учир нь олон нийтийн эрэлт хэрэгцээг хангах чадамжаас тухайн мэдээллийн байгууллагын бараг бүх юм, цаашид бүр тодруулж хэлбэл орших тогтнох эсэх нь шалтгаалах нь тодорхой. Тиймээс судлаач энэ асуудлыг хүний нөөцийн чадамж, хөтөлбөрийн бодлого хөгжүүлэх чадамж, удирдлагын хөгжлийн чадамж гэсэн тулгуур гурван чадамжийн хүрээнд авч үзээд санал асуулга болон бусад аргаар олж авсан баримт, мэдээллийг үндэслэн өнөөгийн байдлаар аль аль нь хангалттай биш байгаа гэсэн дүгнэлтэд хүрчээ. Харин ямар аргаар дээрх гурван чадамжийг сайжруулах талаар тодорхой санал дэвшүүлээгүй, харин сэтгүүлч гэж хэн болох, телевизийн сэтгүүлч ямар мэдлэг, чадварыг эзэмших талаар дэлгэрэнгүй өгүүлээд өнгөрчээ.

Доктор Д.Нарантуяагийн “Монголын нийгмийн оюун санааны амьдралд МҮОНТ-ийн үүрэг, оролцоо” нэг сэдэвт бүтээлийн талаар дээр дурдсан бүхнийг нэгтгэн дүгнэвэл:

Нэгдүгээрт, энэ бүтээл сүүлийн жилүүдэд сэтгүүл зүйн талаар хэвлэгдэн гарсан судалгааны бүтээ-

лүүдээс цөөнгүй шинжээрээ ялгаатай, шинэлэг бүтээл болжээ. Учир нь судлаач ОНМХ-ийн өвөрмөц хэрэгсэл болох телевизийг, тэр дундаа МҮОНТ-ийг нийгмийн оюун санаа хэмээх маш олон зүйлийг өөртөө агуулсан өргөн хүрээний ойлголттой холбон талбарлаж, үндэсний телевиз нийгмийн оюун санааны амьд-

ралд ямар үүрэг гүйцэтгэж ирсэн, гүйцэтгэж байгааг гаргаж өгөхийг оролдсоноороо нэн шинэлэг юм. Зохиолч, сэтгүүлч Б.Наминчимэдийн үгээр хэлбэл, судлаач оюун санааг бүрдүүлж буй ойлголтуудыг “...харьцуулан үзэж, нягтлан судалж, эрэмбэлэн цэгцэлж, нэгтгэн зангидаж, нэгдмэл мэдлэг ойлголт гэж харах үндэстэйг батлах оролдлого хийж, “нийгмийн оюун санааны амьдралын аймаг” гэх шинэ багц болгон томь-

ёолсон нь цаг үеийнхээ сэтгүүл зүйн зүг чигийг онож тодорхойлох шаардлагаас үүсжээ. Энэ нэн чухал эрэл хайгуул юм” (Д.Нарантуяа, 2023).

Энэ бол Монголын сэтгүүл зүй судлал дахь шинэлэг хандлага бөгөөд ОНМХ-ийг олон шинжлэх ухааны зааг дээр судлахыг орчин үеийн дэлхийн сэтгүүл зүй судлалд ч идэвхтэй хэрэглэж байна. Үүнд энэ

«

Энэ бүтээл сүүлийн жилүүдэд сэтгүүл зүйн талаар хэвлэгдэн гарсан судалгааны бүтээлүүдээс цөөнгүй шинжээрээ ялгаатай, шинэлэг бүтээл болжээ. Учир нь судлаач ОНМХ-ийн өвөрмөц хэрэгсэл болох телевизийг, тэр дундаа МҮОНТ-ийг нийгмийн оюун санаа хэмээх маш олон зүйлийг өөртөө агуулсан өргөн хүрээний ойлголттой холбон талбарлаж, үндэсний теле-виз нийгмийн оюун санааны амьдралд ямар үүрэг гүйцэтгэж ирсэн, гүйцэтгэж байгааг гаргаж өгөхийг оролдсоноороо нэн шинэлэг юм

»

бүтээлийн онол-арга зүйн ач холбогдол оршино.

Хоёрдугаарт, судалгааны ажлын онолын үндэслэлийг болон “оюун санаа”, “нийгмийн оюун санаа”, “нийгмийн оюун санааны амьдрал” зэрэг ойлголтуудыг олон талаас нь судалж, өөрийн гэсэн тодорхойлолтыг өгөхийн тулд маш их эх сурвалж ашиглаж, түүнийг өөрийн болгож чадсан нь энэ бүтээлийн бас нэг онцлог мөн. Тиймээс судалгааны ажлын мэдээллийн багтаамж сайтай, урьд өмнө шинжлэх ухааны эргэлтэд ороогүй цөөнгүй баримт, мэдээллийг багтаасан, нийгэм - хүмүүнлэгийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэдэг гол гол аргуудыг оновчтой ашиглаж чадсан, шинэ санаа дэвшүүлж, түүнийг судалгааны үр дүнгээр баталж, өөрийн үнэлэлт, дүгнэлтийг хамгаалж чадсан бүтээл болжээ.

Гуравдугаарт, МҮОНТ-ийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд бодитой үнэлэлт өгч, олон нийтийн статусын зарчим, шалгуурт нийцэж байгаа эсэхийг, Олон нийтийн радио, телевизийн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж чадаж буй эсэхийг олон улсын зарчмуудын дагуу үнэлэн цэгнэж, алдаа оноог шударгаар, зоригтой, итгэл үнэмшилтэй гаргаж өгсөнд энэ бүтээлийн бас нэг онцлог шинж оршино. Нөгөө талаар олон жил энэ телевизэд сэтгүүлчээр ажиллаж, цөөнгүй бүтээл туурвисан хүний хувьд оршиж буй алдаа дутагдлыг маш гярхай, үнэн бодитой ажиглаж чадсан байна. Тиймээс доктор, профессор Т.Баасансүрэн “Бичгийн өндөр соёлтой, их уншдаг, боддог сэтгэдэг, бодож ухаарснаа сайн буулган бичдэг, үнэнийг хавталзтал хэлж чаддаг

сэтгүүлч гэдэг нь нэг сэдэвт бүтээлээс нь илт мэдрэгдэж байна. Ийм нэг шударга, зоригтой, үзэл бодолдоо үнэнч тууштай шинэ залуу судлаачтай болж байгаад баяртай байна” (Д.Нарантуяа, 2023) гэж онож хэлсэн байдаг.

Дөрөвдүгээрт, энэхүү нэг сэдэвт бүтээлийн зарим хэсэгт нийтлэлийн өнгө аяс, уянгын халилын шинж ажиглагдах боловч хэл найруулгын хувьд маш сайн бичигдсэн, уншууртай, дотоод логик холбоо сайтай бүтээл гэдгийг онцлон тэмдэглэж байна. Залуу судлаач бүрд түгээмэл ажиглагддаг өөрийнхөө үзэл бодолд хэт хөтлөгдөн үе үе огцом дүгнэлт хийх хандлага байгаа боловч Д.Нарантуяагийн ажлыг бүхэлд нь авч үзвэл сонгож авсан сэдэвт янз бүрийн өнцгөөс хандаж ул суурьтай судалсан, үнэлэлт дүгнэлт сайтай, асуудалд бүтээлчээр хадсан, онол, практикийн ач холбогдолтой, арга зүйн шинэлэг хандлагыг оновчтой ашиглаж чадсан чамбай бүтээл болжээ. Хамгийн гол нь ОНМХ-ийн тулгамдсан асуудлуудыг нийгэм-хүмүүнлэгийн бусад шинжлэх ухаантай холбон судлах зоригтой алхам хийж, энэ чиглэлийн эхлэлийг тавьсанд эл бүтээлийн үнэт чанар оршино.

Эшлэл

1. Нарантуяа Д. 2023. Монголын шилдэг нийтлэл // Монголын нийгмийн оюун санааны амьдралд МҮОНТ-ийн үүрэг оролцоо. УБ. х.121, 121, 184, 212, 219, 227, 92, 7, 10.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б., Зулькафиль М нар. 2021. Сэтгүүл зүйн үндэс. УБ.

2. Зулькафиль М. 2013. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
3. Зулькафиль М. 2018. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть III. Орчин үеийн медиа: шинэчлэл, чиг хандлага. УБ.
4. Мэндхүү Г., Өнөрсайхан Т. 2014. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.
5. Нарантуяа Б. 2023. Монголын шилдэг нийтлэл. Боть 49. УБ.
6. Өнөрсайхан Т. 2019. Монголын арилжааны телевизүүд: түүх, онол, арга зүй. УБ.

Summary

This review analyzes Dr. D.Narantuya's monograph titled "The Role of Mongolian National Public Television in

the Social Consciousness of Mongolia" and discusses its strengths and weaknesses in detail. Based on this analysis, the review concludes that the merits of this work lie in the fact that the author approached the chosen topic from various angles, thoroughly research it, investigated the problem creatively, made a clear attempt to examine mass media challenges in connection with other disciplines in the social sciences and humanities, and laid the foundation of this approach.

Keywords: Social consciousness, enlightenment, social morality, social ethics, creative thinking, intellectual capacity, sense of ethics, responsibility to enlighten.